

# Contents

- 2 日本語版
- 4 Bản tiếng Việt [ベトナム語版]
- 6 中文版 [中国語版]
- 8 Bersyon sa Pilipino [フィリピン語版]
- 10 Edisi Bahasa Indonesia [インドネシア語版]
- 12 ฉบับภาษาไทย [タイ語版]
- 14 ភាសាខ្មែរ [カンボジア語版]
- 16 မြန်မာဘာသာ မူ [ミャンマー語版]
- 18 Монгол хэл дээрх хувилбар [モンゴル語版]
- 20 English Version [英語版]

## こくごのもり

小学低学年の児童を対象に国語の楽しさを知ってもらおうと、イラストを多用してつくった問題で「毎日小学生新聞」に長期連載。

©毎日小学生新聞 複製、転用はできません

① □ に合う言葉を、下からえらんで書きましょう。

② □ の言葉のさいごの音をのばして書いて言ってみましょう。

どれも □

きれいなけしきを □

かわいがっていた虫が □

なんて...

せんたく物を □

すきな曲を □

つまずいて □

雨が □

大声で □

二時に駅で □

動きを表す言葉

わらう  
ひく  
ほす  
まつ  
しぬ  
ころぶ  
やむ  
ながめる

答えはP22にあります。

# Ур чадварын дадлагажигчийн анд нөхөр

2020 оны 10 дугаар сар, НАМРЫН ДУГААР

## Халдварт өвчний эсрэг авах арга хэмжээ

### — Улирлын чанартай томуу, Шинэ төрлийн коронавирусу —

Өнөөдөр (2020 оны 8 дугаар сар), шинэ төрлийн коронавируст халдвар нэмэгдэж байгаа боловч Японд жил бүрийн 12 дугаар сараас 3 дугаар сар хүртэлх үед улирлын чанартай томуу дэгддэг ба жилд 10 сая орчим хүн халдварлаж байна. Томуу болон шинэ төрлийн коронавирусын аль аль нь **халдварт өвчин** юм. Ур чадварын дадлагажигч Та бүхэн ч халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхийг хичээх нь чухал ба хичнээн хичээсэн ч золгүй тохиолдлоор халдварт өртчихсэн бол, зохистой эмчилгээг хийлгэж, бусдад халдаахгүйн тулд үйлдэлдээ ухамсартай хандах нь чухал юм.

**Томуугийн** шинж тэмдэг нь ханиадныхтай төстэй боловч, гэнэт бие хүйт оргиж, жихүүцсэний дараа өндөр халуурдаг онцлогтой. Нөгөөтэйгөөр, **шинэ төрлийн коронавируст халдварын** шинж тэмдэгт халуурах, ханиалгах, амьсгал давчдах, бие хүйт оргих, жихүүцэх, булчин өвдөх, хоолой өвдөх, амтлах мэдрэхүй эсвэл үнэрлэх мэдрэхүүд хэвийн бус байдал илрэх гэсэн шинж тэмдгүүд дурьдагдаж байна.

Эдгээр халдварт өвчнүүд нь, агаар дуслын замаар халдварлах (халдварлагчийн найтаалга, ханиалга, шүлс зэрэгтэй хамт вирус гадагш гарч, бусад хүн тэр вирусыг нь ам, хамраар сорсноор халдварлах) болон бохирлогдсон гадаргууд хүрэлцсэнээс халдварлах (халдварлагч нь найтаах, ханиалгахдаа гараараа ам хамраа дарсны дараа, тэр гараараа орчин тойрныхоо эд зүйлсэд хүрвэл, халдварлагчийн вирус наалдана. Халдварлаагүй хүн вирус наалдсан тэр хэсэгт нь хүрвэл, халдварлагчийн вирус нь халдварлаагүй хүний гарт наалдаж, халдварлагчид шууд хүрэлцэхгүй байсан ч халдварлах) замаар хүнээс хүнд халдварлана. Өөрийгөө халдварлахаас сэргийлэхийн тулд, юуны өмнө гэртээ харьж ирснийхээ дараа болон хоол хийхийн өмнө, хоол хийсний дараа, мөн хоол идэхийн өмнө гэх мэтчилэн ойр ойрхон гараа угааж (Спирт агуулсан халдваргүйжүүлэгчээр гараа ариутгах нь мөн үр дүнтэй.), хүн ихтэй газар болон хотын төв хэсэг рүү явахаас аль болох татгалзаж, “Зайлсхийх хэрэгтэй 3 нөхцөл байдал (Цэвэр агаарын солилцоо муутай орчин, Олон хүн бөөгнөрсөн газар, Ойрхон зайнаас хүнтэй харилцан ярилцах нөхцөл байдал)”-аас зайлсхийцгээе. Бусадтай биечлэн уулзаж ярилцах тохиолдолд, хоорондынхоо зайг барьж, амны хаалт зүүцгээе. Мөн, бусдад халдаахаас сэргийлэхийн тулд ч амны хаалт зүүж, найтаах, ханиалгахдаа амны хаалт байхгүй бол салфетка, нусны алчуур, хувцасныхаа ханцуйг хэрэглэж ам, хамраа дарцгаая. Чанга дуугаар ярих болон их хэмжээгээр амьсгал гаргадаг дасгал хөдөлгөөн хийх нь халдварлах эрсдэл өндөртэй гэж үзэж байна. Халуурах гэх мэт шинж тэмдэг илэрсэн тохиолдолд ажлаасаа чөлөө авч, гадагшаа гарах болон төрөл бүрийн арга хэмжээнд оролцохоос татгалзацгаая. Дараах хүснэгтэнд харуулсанчлан, өвчний шинж тэмдэггүй вирус тээгчээс бусдад халдварласан тохиолдол (шинж тэмдэггүй халдвар) ч бүртгэгдсэн ба энэ тал дээр шинэ төрлийн коронавирусууд илүү их болгоомжлох хэрэгтэй юм.

Өөрийнхөө төлөө, мөн хамт ажилладаг хүмүүстээ халдаахаас сэргийлэхийн тулд эдгээр анхаарах зүйлсийг баримталж, ирж буй улирлаас эхлэн, томуу болон шинэ төрлийн коронавирусын аль алианаас нь сэргийлэхийг хичээцгээе.

	Томуу	Шинэ төрлийн коронавирус
Далд үе	1-2 хоног	1-14 хоног (Дунджаар 5.6 хоног)
Шинж тэмдэггүй халдвар	10% Өвчний шинж тэмдэггүй вирус тээгч бол, вирусын хэмжээ нь бага байна.	Цөөн % - 60% Өвчний шинж тэмдэггүй вирус тээгч байлаа ч, вирусын хэмжээ нь их, халдварлан тархах хүч нь чанга байна.
Вирус ялгаруулах хугацаа	5-10 хоног (Ихэнх тохиолдолд 5-6 хоног)	Вирусын ген нь урт хугацаагаар илрэх боловч, халдварлан тархах хүчтэй вирус ялгаруулах хугацаа нь 10 хүртэлх хоног
Вирус ялгаруулах оргил үе	Өвчний шинж тэмдэг илэрснээс хойш 2, 3 хоногийн дараа	Өвчний шинж тэмдэг илрэхээс 1 хоногийн өмнө
Вакцин	Вакцин хийлгэх боломжтой ба улирал бүрээр үзүүлэх үр нөлөө нь ялгаатай.	Вакцин гаргахаар судалгаа хийгдэж байгаа хэдий ч өнөөгийн байдлаар үр нөлөөтэй вакцин гараагүй байна.

“Японы халдварт өвчин судлалын холбоо”-ноос дэвшүүлсэн санал “Энэ өвлийн томуу ба COVID-19-д бэлтгэлтэй байх талаар”-аас иш татав.

Лавлагаа холбоос	<p>“Ур чадварын дадлагажигчийн анд нөхөр”-ийн цахим хувилбар</p> <ul style="list-style-type: none"> <li>Ахуйтай холбогдох мэдээлэл &gt; Эрүүл ахуй, эрүүл мэндтэй холбогдох мэдээлэл</li> <li>Ур чадварын дадлагажигчийн гарын авлага руу нэвтрэх холбоос</li> </ul> <p>📍 Томуу (улирлын чанартай)-гийн эсрэг авах арга хэмжээ (Ерөнхий сайдын тамгын газар)  <a href="https://www.kantei.go.jp/jp/headline/kansensho/influenza.html">https://www.kantei.go.jp/jp/headline/kansensho/influenza.html</a></p>	<p>Шинэ төрлийн коронавируст халдварын тухай (Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага)</p> <p>Гадаадын иргэд Та бүхэнд (Шинэ төрлийн коронавируст халдвартай холбогдох мэдээлэл) (Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам)</p> <p>📍 Шинэ төрлийн коронавируст халдварын тухай (Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам)  <a href="https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/0000164708_00001.html">https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/0000164708_00001.html</a></p> <p>📍 Шинэ төрлийн коронавирус (NHK)  <a href="https://www3.nhk.or.jp/news/special/coronavirus/">https://www3.nhk.or.jp/news/special/coronavirus/</a></p>
------------------	---	--

## “28 дахь удаагийн Ур чадварын дадлагажигч гадаад иргэд, сургалтанд хамрагдагчдын Япон хэлний зохион бичлэгийн уралдаан”-ы шагналын эзэд тодров

“28 дахь удаагийн Ур чадварын дадлагажигч гадаад иргэд, сургалтанд хамрагдагчдын Япон хэлний зохион бичлэгийн уралдаан”-д маш олон хүмүүс идэвхтэй оролцсонд талархлаа илэрхийлье. Оролцсон 2,971 бүтээлийн дундаас нарийн хийгдсэн сонгон шалгаруулалтын дүнд, шагналт байранд 28 хүн (Шилдгийн шилдэг бүтээлийн шагнал 4 хүн, Шилдэг бүтээлийн шагнал 4 хүн, Онцгой сайн бүтээлийн шагнал 20 хүн) шалгарч тодорлоо.

<https://www.jitco.or.jp/ja/service/competition.html>

◇ Шилдгийн шилдэг бүтээлийн шагнал (4 хүн)

### Шагналт байранд шалгарсан та бүхэнд баяр хүргэе

Овог нэр	Бүтээлийн сэдэв	Иргэншил	Овог нэр	Бүтээлийн сэдэв	Иргэншил
HA THANH NHAN	マスクなんかいない	Вьетнам	ZHANG QIAOMEI	愛は国境を越えて	Хятад
LE THI YEN	小さな木	Вьетнам	XU HE	魅力的なルール	Хятад

◇ Шилдэг бүтээлийн шагнал (4 хүн)

LIU LICHENGCHUAN	完食	Хятад	ZUN HAY MAR HNIN	綺麗な嘘	Мьянмар
TRAN THI AI LY	看護師にエールを	Вьетнам	ZINAMIDAR SAINBILEG	私の100人のおばあちゃん	Монгол

◇ Онцгой сайн бүтээлийн шагнал (20 хүн)

KONG XIAOQING	友達ができました	Хятад	NGUYEN THI THANH TRANG	私が24歳の時	Вьетнам
BATBAYAR BOLORCHIMEG	この世はねじで出来ている	Монгол	BAT-UCHIR TSATSRAISAUKHAN	挨拶の力とあの笑顔	Монгол
CHEN QINGQING	夢は私のエンジン	Хятад	DI JIA	夢に向かって	Хятад
NITA YUNIAR	きれいになるということの意味	Индонези	ZHANG HONGBO	日本の温泉	Хятад
NGUYEN THI LIEU	心のドア	Вьетнам	XIAO LI	走り続ける	Хятад
WANG XIYAN	親心	Хятад	LI PING	味噌汁が深い	Хятад
NGUYEN THI PHUONG	時雨	Вьетнам	LI SONG	梅の花に思うこと	Хятад
PHAM THI HUONG LY	行列の習慣	Вьетнам	ON THI ANH NGUYET	20歳—初桜の季節	Вьетнам
TRAN THI NGOC TIEN	品質賞のMVPをもらったこと	Вьетнам	LE THI MAI TRANG	努力は報われる。	Вьетнам
NGUYEN THI HOAI	意志あるところに道あり	Вьетнам	DIMAS RIZAL MAULANA HASYIM	働き方改革は何ですか？	Индонези

## Мангагаар дамжуулан мэдэж авцгаая, Япон хүний сэтгэл

— Зүрү зүрү зүү —



### Гоймон сорж идэх дууг сонсоод Маруй сан санаандгүй бодлоо

Японы раамэнд Япончууд өөрсдөө дуртайгаар зогсохгүй, гадаадууд ч дуртай байдаг бөгөөд “Японд ирээд сонирхох зүйл нь раамэний газар орох” гэж ярьдаг хүн ч байдаг. Япончуудын хоолны соёлын нэг болох раамэн гэх мэт гоймонг сорж (дуу гаргаж) идэх соёл нь түгээмэл байдаг боловч, тэр дуунд дасахгүй, эсвэл сорж идэж чадахгүй гэх гадаадуудын санал их сонсогддог. Та бүхэнд ямар мэдрэмж төрдөг вэ?



Hãy điền vào những ô trống trong hình dưới đây những động từ chỉ hành động và trạng thái ở dạng nguyên thể để kết thúc câu. Động từ nguyên thể còn được gọi là “động từ dạng từ điển” vì khi tra từ điển, ta sẽ gặp động từ ở dạng này.  
 Các bạn hãy thử đọc to những động từ đó và khi kéo dài âm cuối ta sẽ thấy tất cả đều kết thúc bằng chữ “う” (u).  
 Thực tế khi sử dụng, chữ cuối của động từ được biến đổi tùy theo các thể khác nhau. Ví dụ: Động từ “ひく”, nghĩa là “kéo” dưới đây, ta có các dạng sau: “ひかない、ひきます、ひく、ひけば...” (hikanai, hikimasu, hiku, hikeba...)  
 Trong từ tin này, chúng tôi thường không dùng cách viết sử dụng thể nguyên dạng để kết thúc câu.

下面的词汇是表示动作、作用·存在等的动词的终止形。也是查国语词典的时候出现的词条。  
 读出声音来，把最后一个音拖长，无论哪个都是「ウ」。  
 实际使用时，像「ひかない、ひきます、ひく、ひけば……」等，词汇的终止形式会发生变化。本杂志中，比起终止形，其他形式使用得更多。

Ang mga salita sa ibaba ay ang pangwakas na anyo ng mga pandiwa na nagpapahayag ng mga aksyon, kilos, pag-iral at iba pa. Isa rin itong punong salita kapag titignan sa isang diksiyunaryong hapon.  
 Kung babasahin mo ito nang malakas at pahabain ang huling tunog, ang lahat ay magiging "U".  
 Kapag aktwal na ginamit mo talaga ito, magbabago ang pagtatapos ng mga salita, tulad ng 「ひかない、ひきます、ひく、ひけば……」 Ang mga pandiwa ay madalas na ginagamit sa iba pang mga form kaysa sa pangwakas na anyo.

Kata-kata di bawah ini merupakan bentuk akhir dari kata kerja yang mengungkapkan gerak, aksi dan keberadaan. Ini juga merupakan kata kepala saat mengacu pada kamus bahasa Jepang.  
 Jika Anda membacanya dengan mengeluarkan suara dan memperpanjang bunyi terakhir, semua berakhir dengan "u".  
 Akan tetapi, dalam penggunaan sebenarnya, akhirnya kata akan berubah, seperti "hikanai, hikimasu, hiku, hikeba, ...". Bentuk kata kerja lebih sering digunakan dalam bentuk lain daripada bentuk akhir.

คำด้านล่างเป็นรูปพจนานุกรมของคำกริยาที่แสดงถึงการเคลื่อนไหว การกระทำและการมีอยู่เป็นคำหลักที่ใช้ดูเวลาเปิดหาคำศัพท์ในพจนานุกรมภาษาญี่ปุ่น หากอ่านออกเสียงและยืดเสียงตัวสุดท้ายออกก็จะพบว่า ทุกคำจะลงท้ายด้วยเสียง “อุ”  
 เวลาที่ใช้จริงก็จะเปลี่ยนเสียงลงท้ายคำเป็น “ฮิกันะอิ, ฮิคิมะซุ, ฮิคุ, ฮิเคะบะ.....” เป็นต้น ซึ่งคำที่ปรากฏในวารสารนี้มักจะใช้รูปอื่นเสียงมากกว่ารูปพจนานุกรม

ពាក្យខាងក្រោមនេះ គឺជាទម្រង់កិរិយាសព្វដើមដែលបង្ហាញអំពីចលនា សកម្មភាព ឬ សភាពជាដើម។ នៅពេលដែលអ្នកបើករចនាស្រុកសាសាជប៉ុន អ្នកក៏នឹងឃើញពាក្យនេះ។ នៅពេលដែលអ្នកអានបញ្ចេញសម្លេង ដោយបង្អួសបង្អួលដែលនៅខាងក្រោយគេ មួយណាក៏មានសម្លេង 「ウ」 ដែរ។ ជាក់ស្តែងនៅពេលដែលយើងប្រើប្រាស់ភាសាជប៉ុន ពាក្យដែលនៅចុងក្រោយគេគឺ 「ひかない、ひきます、ひく、ひけば……」 រួមបញ្ចូលសក្ខីភាពសព្វគឺ ត្រូវបានគេប្រើជាញឹកញាប់ក្នុងទម្រង់ប្រាយផ្សេង ជាជាងទម្រង់ប្រាយកិរិយាសព្វដើម។

အောက်မှာပါတဲ့ စကားလုံးတွေဟာ ပြုခြင်း၊ ဖြစ်ခြင်း၊ ရှိခြင်းတွေကို ဖော်ပြတဲ့ကြိယာရဲ့ အဆုံးသတ်ပုံစံတွေပါ။ အဘိဓာန် မာဝိကာအဖြစ်သုံးတဲ့ စကားလုံးလည်း ဖြစ်ပါတယ်။  
 အသံထွက်ပြီးဖတ်တဲ့အခါ နောက်ဆုံး အသံကို ဆွဲပြောရင် အားလုံး 「ウ」 ဖြစ်ပါတယ်။  
 လက်တွေ့သုံးရာမှာ 「ひかない、ひきます、ひく、ひけば……」 စသဖြင့် စာလုံးရဲ့နောက်ဘက်ပိုင်း ပြောင်းလဲပါတယ်။ ကြိယာတစ်ခုကို အဆုံးသတ်ပုံစံထက် တခြားပုံစံတွေနဲ့ အသုံးပြုတာ ပိုများပါတယ်။

Дараах үгүүд нь үйлдэл болон нөлөөлөл, оршихуйг илэрхийлдэг үйл үгүүдийн үндсэн хэлбэр нь юм. Мөн энэ хэлбэр нь Япон хэлний тайлбар толины толгой үг болдог.  
 Дуу гарган уншиж, төгсгөлийнх нь авиаг сунгавал, бүгдээрээ “u/ウ” байна.  
 Харин бодитоор хэрэглэгдэхдээ, “hikanai/ひかない、hikimasu/ひきます、hiku/ひく、hikeba/ひけば...” гэх мэтчилэн үгийн төгсгөлийн хэлбэр нь өөрчлөгддөг. Үйл үг нь үндсэн хэлбэрээсээ илүү бусад хэлбэрээр хэрэглэгдэх нь их тохиолддог.

The words at the bottom are verbs that express a movement, action or existence in terminal form. The terminal form is also called dictionary form, because words appear in this form when you look them up in the dictionary.  
 Read them out loud and stretch the last sound. You will find that they all end with the “ウ” sound.  
 When actually using these verbs, however, the verb ending changes. For example, “ひく” may be used as “ひかない,” “ひきます,” “ひく,” “ひけば” and so on. In this way, verbs are used more frequently in forms other than the terminal form.

技能実習生・研修生向母国語情報誌 発行 公益財団法人 国際人材協力機構 (JITCO)  
**技能実習生の友** 総務部広報室  
 2020年10月 秋季号 〒108-0023  
 東京都港区芝浦 2-11-5  
 五十嵐ビルディング  
 2020年10月1日発行 電話 03-4306-1166 (ダイヤルイン)  
 JITCO ホームページ https://www.jitco.or.jp/